



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/256-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn
Сүхбаатар сум
2024 он

ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх
Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: "Пийк Ом Аудит" ХХК
Утас: 99052418 Цахим хаяг: cheegii9989@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13-17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13-14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14-15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15-17
4. Аудитын тайлан	17-20
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19-20
5. Аудитын илрүүлэлт	21-22
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БЕГ	Боловсролын ерөнхий газар
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
НА	Нийцлийн аудит
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТАГ	Төрийн аудитын газар
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр ажил үйлчилгээ
худалдах авах тухай	
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

МАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 1 ДҮГЭЭР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Ж.ТӨМӨРЧӨДӨР ТАНАА

2024.02.22 № САА-2024/258-НА-СТА-7443
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мандал сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд БЕГ-аас 4,189.6 мянган төгрөгийн ном, БШУГ-аас 7,463.1 мянган төгрөгийн өртөг бүхий хими технологийн кабинетын хэрэглэгдэхүүн, Алтантариа ХХК-иас 12,682.6 мянган төгрөгийн, иргэдээс 5,130.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна.

Тус сургууль нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/324 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 4 дүгээр түвшинд үнэлэгдэж урамшуулалд 26,531.4 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 96 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 96.8 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	230,520,106.13	479,017,819.64
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	21,868,475.81	259,929,550.20
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	21,868,475.81	259,929,550.20
3121	Төгрөг	21,868,475.81	259,929,550.20
31211	Төрийн сангийн харилцах	21,868,475.81	259,929,550.20
35	БАРАА МАТЕРИАЛ	208,651,630.32	219,088,269.44
351	Түүхий эд материал	48,762,096.43	54,922,848.87
3511	Тусгай зориулалттай материал	48,671,011.43	54,795,613.87
3513	Эм боох материал	91,085.00	127,235.00
354	Хангамжийн материал	159,889,533.89	164,165,420.57
3541	Бичиг хэргийн материал	235,888.00	235,888.00
3547	Бусад хангамжийн материал	159,653,645.89	163,929,532.57
36	НӨӨЦИЙН БАРАА		
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,564,584,158.07	3,516,419,223.42
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,564,584,158.07	3,516,419,223.42
392	Биет хөрөнгө	2,497,765,408.17	2,372,011,973.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,166,259,068.00	2,166,259,068.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-326,253,010.80	-418,399,809.36
39203	Авто-тээврийн хэрэгсэл	6,750,000.00	6,750,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-2,250,000.00	-4,500,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	354,624,436.83	499,546,670.83
39206	Хуримтлагдсан элэгдэл	-182,490,557.17	-314,063,279.63
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	130,275,602.74	205,878,290.18
39208	Хуримтлагдсан элэгдэл	-69,112,466.50	-143,582,558.59
39214	Бусад үндсэн хөрөнгө	497,361,335.47	371,852,272.03
39215	Хуримтлагдсан элэгдэл	-154,362,778.28	-84,260,751.18
39217	Ном	76,963,777.88	86,532,071.28
393	Биет бус хөрөнгө	1,066,818,749.90	1,144,407,249.86
39301	Программ хангамж	2,202,632.00	2,202,632.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,583,882.10	-1,971,382.14
39303	Бусад биет бус хөрөнгө	1,066,200,000.00	1,144,176,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,795,104,264.20	3,995,437,043.06
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	9,217,635.44	
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,217,635.44	
413	Өглөг	9,217,635.44	
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	9,217,635.44	
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,785,886,628.76	3,995,437,043.06
51	Засгийн газрын хувь оролцоо	3,785,886,628.76	3,995,437,043.06

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,367,675,453.39	2,367,675,453.39
51101	Өмч: - төрийн	2,367,675,453.39	2,367,675,453.39
512	Хуримтлагдсан үр дүн	-141,004,095.74	68,546,318.56
5121	Өмнөх үеийн үр дүн	-141,004,095.74	-141,004,095.74
5122	Тайлант үеийн үр дүн		209,550,414.30
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,559,215,271.11	1,559,215,271.11
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,795,104,264.20	3,995,437,043.06

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

		/төгрөгөөр/	
Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,200,003,711.92	3,069,204,193.49
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,002,668,544.90	149,663,246.84
120	Нийтлэг татварын бус орлого	4,002,668,544.90	149,663,246.84
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,309,500.00	19,595,286.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,274,500.00	16,404,698.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	3,190,588.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	3,782,342,848.26	107,441,353.40
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	214,016,196.64	22,626,607.44
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,197,335,167.02	2,919,540,946.65
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,962,784,300.00	2,736,375,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,962,784,300.00	2,736,375,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	159,000.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	159,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	234,391,867.02	183,165,046.65
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	234,391,867.02	183,165,046.65
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,417,471,475.71	2,859,653,779.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,417,471,475.71	2,859,653,779.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,292,463,525.71	2,738,742,129.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,561,712,817.60	1,938,017,679.00
210101	Үндсэн цалин	1,148,923,554.50	1,368,601,264.86
210102	Нэмэгдэл	349,533,207.10	476,523,022.14
210104	Урамшуулал	63,256,056.00	92,893,392.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	194,368,702.18	239,585,222.22
210201	Тэтгэврийн даатгал	132,195,686.18	166,028,463.40
210202	Тэтгэмжийн даатгал	15,353,963.00	21,463,504.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,623,904.00	12,458,495.66
210204	Ажилгүйдлийн даатгал	3,108,541.00	8,203,579.83
210205	Эрүүл мэндийн даатгал	31,086,608.00	31,431,178.75

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	115,244,762.68	170,072,446.65
210301	Гэрэл, цахилгаан	27,874,882.68	40,257,329.65
210302	Түлш, халаалт	68,120,580.00	105,075,000.00
210303	Цэвэр, бохир ус	19,249,300.00	24,740,117.00
2104	Хангамж, бараа материалын зардал		9,886,478.32
210408	Бараа материал акталсны зардал		9,886,478.32
2105	Нормативт зардал	31,516,880.00	40,538,350.00
210502	Хоол, хүнс	31,516,880.00	40,538,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,044,250.00	16,212,200.00
210604	Урсгал засвар	20,044,250.00	16,212,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,746,300.00	20,023,878.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,274,500.00	7,120,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,471,800.00	12,903,178.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	355,829,813.25	304,405,875.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,134,258.74	48,283,000.95
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,827,064.32	25,397,788.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	306,868,490.19	230,725,086.05
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	125,007,950.00	120,911,650.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	125,007,950.00	120,911,650.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	107,839,950.00	103,666,250.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,168,000.00	17,245,400.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	3,782,532,236.21	209,550,414.30
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	3,782,532,236.21	209,550,414.30

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Данс	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,206,999,059.57	2,939,136,232.65
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,663,892.55	19,595,286.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,663,892.55	19,595,286.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,663,892.55	19,595,286.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,628,892.55	16,404,698.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	3,190,588.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,197,335,167.02	2,919,540,946.65
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,962,784,300.00	2,736,375,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,962,784,300.00	2,736,375,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	159,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	159,000.00	

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	234,391,867.02	183,165,046.65
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	234,391,867.02	183,165,046.65
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,096,020,783.76	2,625,956,360.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,096,020,783.76	2,625,956,360.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,971,012,833.76	2,505,044,710.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,552,573,486.34	1,938,102,508.00
210101	Үндсэн цалин	1,148,923,554.50	1,368,601,264.86
210102	Нэмэгдэл	340,393,875.84	476,607,851.14
210104	Урамшуулал	63,256,056.00	92,893,392.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	194,290,398.00	248,718,028.66
210201	Тэтгэврийн даатгал	132,117,582.00	169,895,834.17
210202	Тэтгэмжийн даатгал	15,353,963.00	21,463,504.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,623,904.00	15,658,495.66
210204	Ажилгүйдлийн даатгал	3,108,541.00	8,203,579.83
210205	Эрүүл мэндийн даатгал	31,086,408.00	33,496,614.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	109,993,182.68	170,072,446.65
210301	Гэрэл, цахилгаан	27,874,882.68	40,257,329.65
210302	Түлш, халаалт	62,869,000.00	105,075,000.00
210303	Цэвэр, бохир ус	19,249,300.00	24,740,117.00
2104	Хангамж, бараа материалын зардал		
2105	Нормативт зардал	31,071,880.00	40,538,350.00
210502	Хоол, хүнс	31,071,880.00	40,538,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,645,600.00	13,092,600.00
210604	Урсгал засвар	19,645,600.00	13,092,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,746,300.00	20,023,878.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,274,500.00	7,120,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,471,800.00	12,903,178.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,691,986.74	74,496,898.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,700,586.74	53,481,410.95
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,991,400.00	21,015,488.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	125,007,950.00	120,911,650.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	125,007,950.00	120,911,650.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	107,839,950.00	103,666,250.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,168,000.00	17,245,400.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	110,978,275.81	313,179,872.39
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	89,109,800.00	75,118,798.00
	Дотоод эх үүсвэрээр	89,109,800.00	75,118,798.00
222001	Тоног төхөөрөмж	77,843,800.00	67,246,798.00
223001	Бусад хөрөнгө	11,266,000.00	7,872,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-89,109,800.00	-75,118,798.00

VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	21,868,475.81	238,061,074.39
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		21,868,475.81
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		259,929,550.20

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,367,675,453.39	1,559,215,271.11	-141,004,095.74	3,785,886,628.76
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			209,550,414.30	209,550,414.30
19	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,367,675,453.39	1,559,215,271.11	68,546,318.56	3,995,437,043.06

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,971,128,900.00	2,701,075,158.26	270,053,741.74	90.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,971,128,900.00	2,701,075,158.26	270,053,741.74	90.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,826,488,500.00	2,580,163,508.26	246,324,991.74	91.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,143,827,200.00	1,938,102,508.00	205,724,692.00	90.4
210101	Үндсэн цалин	1,483,743,100.00	1,368,601,264.86	115,141,835.14	92.2
210102	Нэмэгдэл	558,243,900.00	476,607,851.14	81,636,048.86	85.4
210104	Урамшуулал	101,840,200.00	92,893,392.00	8,946,808.00	91.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	267,978,700.00	248,718,028.66	19,260,671.34	92.8
210201	Тэтгэврийн даатгал	182,225,600.00	169,895,834.17	12,329,765.83	93.2
210202	Тэтгэмжийн даатгал	21,438,300.00	21,463,504.58	-25,204.58	100.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,150,700.00	15,658,495.66	1,492,204.34	91.3
210204	Ажилгүйдлийн даатгал	4,287,600.00	8,203,579.83	-3,915,979.83	191.3
210205	Эрүүл мэндийн даатгал	42,876,500.00	33,496,614.42	9,379,885.58	78.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	186,713,300.00	170,072,446.65	16,640,853.35	91.1
210301	Гэрэл, цахилгаан	45,102,800.00	40,257,329.65	4,845,470.35	89.3
210302	Түлш, халаалт	117,286,000.00	105,075,000.00	12,211,000.00	89.6
210303	Цэвэр, бохир ус	24,324,500.00	24,740,117.00	-415,617.00	101.7
2104	Хангамж, бараа материалын зардал				

2105	Нормативт зардал	43,203,100.00	40,538,350.00	2,664,750.00	93.8
210502	Хоол, хүнс	43,203,100.00	40,538,350.00	2,664,750.00	93.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,092,600.00	19,538,598.00	-6,445,998.00	149.2
210601	Багаж, техник, хэрэгсэл		6,445,998.00	-6,445,998.00	
210604	Урсгал засвар	13,092,600.00	13,092,600.00		100.0
2107	Томилолт, зочны зардал				
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,386,400.00	20,023,878.00	362,522.00	98.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,120,700.00	7,120,700.00		100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,265,700.00	12,903,178.00	362,522.00	97.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	151,287,200.00	143,169,698.95	8,117,501.05	94.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	130,143,700.00	122,026,210.95	8,117,489.05	93.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,143,500.00	21,143,488.00	12	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	144,640,400.00	120,911,650.00	23,728,750.00	83.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	144,640,400.00	120,911,650.00	23,728,750.00	83.6
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	127,395,000.00	103,666,250.00	23,728,750.00	81.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,245,400.00	17,245,400.00		100.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,971,128,900.00	2,939,136,232.65	31,992,667.35	98.9
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,758,243,700.00	2,736,375,900.00	21,867,800.00	99.2
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,736,375,900.00	2,736,375,900.00		100.0
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	21,867,800.00		21,867,800.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого				
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	199,805,900.00	183,165,046.65	16,640,853.35	91.7
132001	Орон нутгийн төсвөөс	199,805,900.00	183,165,046.65	16,640,853.35	91.7
133	ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС				
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	13,079,300.00	19,595,286.00	-6,515,986.00	149.8
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		16,404,698.00	-16,404,698.00	
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,155,600.00	3,190,588.00	-34,988.00	101.1
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР				
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		21,868,475.81	-21,868,475.81	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		259,929,550.20	259,929,550.20	
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
5	АЖИЛЛАГСДЫН ТОО	114	111		97.3
24	СУРАЛЦАГЧДЫН ТОО	1148	1109		96.6

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мандал сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь “Эвсэг чадварлаг хамт олон ээлтэй орчин бүрдүүлж, бие даан сурах чадвартай бүтээлч Монгол иргэдийг төлөвшүүлнэ.” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна

Тус байгууллага нь дараах чиг үүрэгтэй ажилласан байна. Үүнд:

- Хүүхдийн нийгэм сэтгэл зүй, танин мэдэхүйн хөгжлийг дэмжих,
- Боловсрол эзэмшихэд тулгарч буй бэрхшээлийг арилгаж сурах тэгш боломж бүрдүүлэх,
- Хувь хүний онцлогт нийцүүлэн сургалт, үйл ажиллагааг чанар үр дүнтэй зохион байгуулах,
- Хамтран суралцах арга барилыг сургалтад нэвтрүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд батлагдсан,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,*
- *БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд 1."ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх", 2."Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом,наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх,худалдан авах ажиллагааг зохион байгуулах" чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мандал сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 200,332.8 мянган төгрөгөөр буюу 5.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	21,868.5	259,929.6	238,061.1
Авлага			
Бараа материал	208,651.6	219,088.3	10,436.6
Үндсэн хөрөнгө	3,564,584.2	3,516,419.2	(48,164.9)
Нийт хөрөнгө	3,795,104.3	3,995,437.0	200,332.8
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,795,104.3	3,995,437.0	200,332.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,795,104.3	3,995,437.0	200,332.8

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 259,929.6 мянган төгрөг болж 238,061.1 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлтийг Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх “Энэ хуулийн 7.7 дахь хэсэг зрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Бараа материал дансны үлдэгдэл 219,088.3 мянган төгрөг болж 10,436.6 мянган төгрөгөөр өссөн нь БЕГ-аас 6,124.6 мянган төгрөгийн ном, БШУГ-аас 12,943.6 мянган төгрөгийн хими, технологийн кабинетын хэрэглэгдэхүүн, иргэд аж ахуйн нэгжээс 3,558.4 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй авч, төсвийн хөрөнгөөр 301,067.6 мянган төгрөгийн худалдан авалт хийж, үйл ажиллагаанд 303,371.1 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулан, сургуулийн захирлын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/34 дүгээр тушаалын дагуу цаашид ашиглах боломжгүй 9,886.5 мянган төгрөгийн бараа материалыг акталж данс бүртгэлээс хассанаас,

- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,516,419.2 мянган төгрөг болж 48,164.9 мянган төгрөгөөр буурсан нь БЕГ-аас 4,189.6 мянган төгрөгийн ном, аймгийн хөрөнгө оруулалтаар 7,463.1 мянган төгрөгийн өртөг бүхий хими технологийн кабинетын хэрэглэгдэхүүн, иргэд аж ахуйн нэгжээс 17,812.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ширээ сандлыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, хур системээс 77,976.0 мянган төгрөгийн өртөг бүхий газрыг хөрөнгөөр бүртгэж, төсвийн хөрөнгөөр 75118.8 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан болон аймгийн ОНӨГ-ын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 609 дүгээр албан бичгийг үндэслэн 131,083.1 мянган төгрөгийн хөрөнгийг данс хооронд шилжүүлэн 230,725.1 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцоноос тус тус шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 1,925,224.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 161,837.90 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 5,064.2 мянган төгрөг нийт 2,092,126.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг 64,732.7 мянган төгрөгөөр буюу цалин хөлсийг 29,164.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 12,059.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, тогтмол зардлыг 19,257.0 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 79,281.4 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 5,890.3 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 1,527.7 мянган төгрөгөөр буруулж нийт 2,027,393.8 мянган төгрөгөөр баталсан байна.

2023 онд төсөвт 3 удаа өөрчлөлт орж 11 дүгээр сард цалин хөлсийг 748,728.7 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 85,171.5 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 57,915.3 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 39,466.8 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 5,200.0 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 7,252.8 мянган төгрөгөөр нийт 943,735.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн улсын төсвөөс 2,736,375.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 199,805.9 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлогоос 13079.3 мянган төгрөгийн, урьд оны үлдэгдлээс 21,867.8 мянган төгрөг зарцуулахаар төсвийг нийт 2,971,128.9 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу нийт 2,971,128.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 2,701,075.2 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 16,640.9 мянган төгрөгийг төвлөрүүлж, 253,412.8 мянган төгрөгийг хэмнэж үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,701,075.2 мянган төгрөг буюу 90.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 246,324.9 мянган төгрөгөөр, үдийн цай хөтөлбөрийн зардлыг 23,728.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна
Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
1	71802 Ерөнхий боловсрол	1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	5,321.6	5,321.6	-	100.0
		2	80312- Сургалт семинар	3,562.3	3,210.6	351.7	90.1
		3	81605- Эрүүл мэндийг дэмжих	8,146.0	8,092.0	54.0	99.3
		4	81801- Үдийн цай хөтөлбөр	127,395.0	103,666.3	23,728.8	81.4
		5	81806-Дотуур байр	43,203.1	40,538.4	2,664.8	93.8
		5	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	59,276.9	59,276.9	-	100.0
		6	81823- Боловсролын багшийн сургалт	12,007.9	11,465.4	542.5	95.5
			81827-Бичиг үсгийн боловсрол	72,450.0	66,148.3	6,301.7	91.3
		7	81834- Боловсролын стандарт сургалт	1,968,390.7	1,788,674.1	179,716.6	90.9
		8	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	471,582.8	425,083.9	46,498.9	90.1
		9	81844- Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	2,838.0	2,838.0	-	100.0
		10	83603-сурах бичгийн түрээс	7,120.7	7,120.7	-	100.0
11	83603- Дээд шатны төсвөөс	3,120.6	9,566.6	(6,446.0)	306.6		
12	80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	186,713.3	170,072.4	16,640.9	91.1		
		Нийт		2,971,128.9	2,701,075.2	270,053.7	90.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулан хоол хүнсний 141,123.4 мянган төгрөг, нүүрсний 84,320.0 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээг гүйцэтгэх бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтыг зарлаж “Күзмен тайж” ХХК нүүрс, “Их наран булаг” ХХК хоол хүнс нийлүүлэхээр шалгарч гэрээ байгуулан, худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Мандал сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал,

дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Пийк Ом Аудит” ХХК-ийн аудитор Б.Наранчимэг, чанарын хяналтыг компанийн захирал Б.Жаргалсайхан, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Пийк Ом Аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,417,471.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 24,174.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Мандал сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд тус сургуулийн үйл ажиллагаанд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Пийк Ом аудит” ХХК-ийн 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 214 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн

бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийг зүй зохистой удирдаагүйгээс 9,217.6 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн, бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулж цахим системд шивээгүй 6,274.5 мянган төгрөгийн, анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээг бүртгэлд тусгасан 7,800.0 мянган төгрөгийн, хөрөнгийг эдийн засгийн ангилал буруу бүртгэсэн 49,436.9 мянган төгрөгийн зөрчил илэрч 2 албан шаардлага, 2 зөвлөмж өгөгдсөн байна.

Албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	57,236.9	2	57,236.9	100.0
Албан шаардлага	2	15,492.1	2	15,492.1	100.0
Нийт дүн	4	72,729.0	4	72,729.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн нь 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 2/3151 дүгээр албан бичгээр тус яамны харьяа төсвийн шууд захирагч нарт “2022 оны санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, “Итгэл үзүүлсэн”, “Түүвэрт хамрагдсан” гэж дүгнэгдсэн байгууллагуудын төсөв, санхүүгийн ажилтан нарт батлагдсан төсөвтөө багтаан балансын урамшууллыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг үндэслэн олгож болно” гэж хууль, эрхийн актад заагдаагүй балансын урамшуулал гэгчийг олгохыг зөвшөөрсөн байна.

Уг албан бичгийн дагуу дараах албан хаагчдын ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 45.0 хүртэл хувиар тооцон үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал тус бүр нэг сарын үндсэн цалинтай тэнцэх буюу нийт 1,290.1 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна. Үүнд:

- Нягтлан бодогч Р.Байгальмаад 875.3 мянган төгрөг,
- Нярав А.Ганчимэгт 414.8 мянган төгрөг.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно.”, 15.1.3 : “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.